

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 22/06

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн ТУЗ-ийн даргаар Очирсүрэн овогтой Болдбаатар (РД: ЙЮ80100817)-ыг сонгосугай.
2. Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм, Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, холбогдох бусад баримт бичгийг мөрдөж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дарга (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.
3. Компанийн ТУЗ-ийн дарга сонгогдсонтой холбоотойгоор Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршсан мэдээлэлд өөрчлөлт оруулан олон нийтэд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал), Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

/О.БОЛДБААТАР/

/Ц.УУГАНБАЯР/

/В.БАЯРСАЙХАН/

/Б.ХОС-ЭРДЭНЭ/

/Ж.ЖАРГАЛСҮРЭН/

/Д.ГАЛХҮҮ/

/С.БОРГИЛ/

/Б.ИТГЭЛ/

/С.ЭНХ-АМГАЛАН/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 22/07

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн санал, Компанийн ТУЗ-ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Батсүлд овогтой Оюунболд (РД: ДИ94102812)-ыг томилсугай.
2. Монгол Улсын Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм, Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, холбогдох бусад баримт бичгийг мөрдөж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.
3. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга шинээр томилогдсонтой холбоотойгоор холбоотойгоор Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршсан мэдээлэлд өөрчлөлт оруулан олон нийтэд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэх, ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай хөдөлмөрийн гэрээ байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 22/08

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйл, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:
 - 1.1. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо:
Хорооны дарга: Б.Итгэл
Гишүүд: С.Энх-Амгалан;
В.Баярсайхан;
Д.Галхүү;
Ц.Ууганбаяр;
Б.Хос-Эрдэнэ.
 - 1.2. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо:
Хорооны дарга: Ж.Жаргалсүрэн
Гишүүд: С.Боргил;
О.Болдбаатар.
 - 1.3. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хороо:
Хорооны дарга: С.Энх-Амгалан
Гишүүд: С.Боргил;
Д.Галхүү.
2. Монгол Улсын Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм, Компанийн үйл ажиллагааны журам, холбогдох бусад баримт бичгийг мөрдөж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршсан мэдээлэлд өөрчлөлт оруулан олон нийтэд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал), Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 22/09

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны ээлжит хурлын хуваарь батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.8 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2022 оны ээлжит хурлын хуваарийг энэхүү тогтоолын хавсралт №1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлыг тогтоосон хугацаанд хуралдуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д, түүнд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дарга (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 22 / 10

Улаанбаатар хот

**Компанийн 2022 оны үйл ажиллагааны
төлөвлөгөө, төсөв батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны төсвийг энэхүү тогтоолын Хавсралт №2-оор баталсугай.
3. Компанийн үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө, төсвийн зорилтыг хэрэгжүүлж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 22/11

Улаанбаатар хот

Компанийн бүтцэд өөрчлөлт оруулах эрх олгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.10 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн бизнесийн өсөлт хөгжил, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан Компанийн үйл ажиллагааг оновчтой удирдан зохион байгуулах, Компанийн хүний нөөцийг үр дүнтэй хуваарилж, ашиглах зорилгоор Компанийн бүтцэд тухай бүр өөрчлөлт оруулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
2. Компанийн бүтцэд хийх өөрчлөлтийг Компанийн ТУЗ-өөс баталсан 2022 оны төсвийн хүрээнд, 2022 оны төсөвт нийцүүлэн хийж гүйцэтгэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д даалгасугай.
3. Компанийн бүтцийг өөрчлөхтэй холбогдуулан Компанийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, Компанийн алба, хэлтэс, нэгжийн албан тушаалтныг чиг үүргээр ханган, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 22/12

Улаанбаатар хот

Репо арилжаанд оролцох эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.22, 9.6.23 дахь заалт, болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн эх үүсвэрийг үр ашигтай удирдах зорилгоор Репо арилжаанд зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрхтэйгээр оролцох эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
2. Компани Репо арилжаанд оролцоход баримтлах ерөнхий нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Батлагдсан ерөнхий нөхцөлийн дагуу Репо арилжаанд оролцохтой холбогдуулан “Мони Маркет Фанд” ХХК-тай холбогдох гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
4. Репо арилжаанд оролцохдоо Компанийн эрх ашиг болон дотоод бодлогод нийцүүлэн оновчтой тодорхойлох, үр ашигтай түвшинд удирдан зохион байгуулж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



УЛААНБААТАР ХОТ
/О.БОЛДБААТАР/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 22/13

Улаанбаатар хот

Гэрээний хугацаа сунгах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагаанд шаардлагатай нарийн мэргэжлийн ур чадвар бүхий ажил гүйцэтгүүлэхэд зориулан “АНД Системс” ХХК-тай байгуулсан “Менежментийн үйлчилгээний гэрээ”-г уг гэрээний үндсэн нөхцөлөөр, 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 1 (нэг) жилийн хугацаатай сунгах болон бусад нөхцөлийг хэлэлцэн тохирч гэрээ байгуулах, уг гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
2. Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан “АНД Системс” ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 22 / 14

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн эрхлэн явуулж буй “LendPay” үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, боловсролын салбарт ажиллаж буй байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор “Томё ЭдТек” ХХК-тай “LendPay үйлчилгээнд хамтран ажиллах гэрээ” байгуулахаар шийдвэрлэсүгэй.
2. “Томё ЭдТек” ХХК-тай байгуулах “LendPay үйлчилгээнд хамтран ажиллах гэрээ”-ний нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталж, уг гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын дагуу “Томё ЭдТек” ХХК -тай байгуулсан гэрээний хэрэгжилтийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 22/15

Улаанбаатар хот

Эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зүгээс Монгол Улсын нутаг дэвсгэрт 2021 оны 8-р сарын 3-ны өдөр хүртэл онцгой эрхтэйгээр ашиглах эрхтэй LendMN 2.0 программ хангамжийг Компанийн технологийн түнш байгууллага “АНД Сольюшнс ПТИ. ЛТД” (цаашид “АСОЛ” гэх)-ийн зүгээс хөгжүүлэхэд ашигласан Хавсралт 1-д дурдсан функцуудыг “АСОЛ” нь өөрийн шинээр хөгжүүлж буй Core banking middleware болон UaaS Solution-д хязгаарлагдмал хүрээнд ашиглах хүсэлт гаргасан.

- Core banking middleware болон UaaS Solution программ хангамжууд нь LendMN 2.0 программ хангамжтай Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шууд байдлаар өрсөлдөхгүйг харгалзан,
- “АСОЛ” болон Компанийн зүгээс финтек технологийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хамтран хөгжүүлэх, төгөлдөржүүлэх урт хугацааны түншлэлийн хүрээнд Компани нь “АСОЛ”-ийн шинээр санаачилсан, бүтээсэн, хөгжүүлсэн, инноваци шингэсэн финтек технологийн бүтээгдэхүүн, функцуудыг LendMN 2.0 программ хангамжид аливаа үнэ төлбөргүйгээр “АСОЛ”-аар нэвтрүүлүүлэх, үйл ажиллагаандаа ашиглах бүрэн эрхтэйг харгалзан,
- “АСОЛ”-ийн шинээр хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлэх гэж буй Core banking middleware болон UaaS Solution нь LendMN 2.0 программ хангамжийн цаашдын хөгжилд шаардлагатай байж болох Document management system, Content management system, Asset valuation system, Autoscale system зэрэг функцуудыг багтаасан байгаа ба тэдгээр функцуудыг “АСОЛ” нь LendMN 2.0 программ хангамжид талуудын хооронд байгуулсан гэрээний хүрээнд үнэ төлбөргүй нэвтрүүлэх сонирхолтой байгааг харгалзан,

Core banking middleware болон UaaS Solution программ хангамжид LendMN 2.0 программ хангамжид ашигласан Хавсралт 1-д дурдсан функцуудыг ашиглах нь талуудын хооронд байгуулсан програм хангамжийн гэрээний 6.5-р заалтад зөрчилдөхгүй тухай мэдэгдлийг “АНД Сольюшнс ПТИ. ЛТД”-д гаргаж өгөх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.

2. Core banking middleware болон UaaS Solution программ хангамжийг хөгжүүлэхэд шинээр үүссэн, LendMN 2.0 програм хангамжийн үйл ажиллагааг дэмжихүйц зарим функцийг LendMN 2.0 программ хангамжид үнэ төлбөргүйгээр нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

№ 22 / 16

Улаанбаатар хот

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж ажиллах, гүйцэтгэлийг Компанийн ТУЗ-д тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.
3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн батлагдсантай холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, шаардлагатай өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



/О.БОЛДБААТАР/

